

СЭЛЭНГЭ АЙМГИЙН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ 2017- XII





ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ



2017 оны жилийн эцэст суурин хүн амын тоо 108768 -д хүрсэн нь өмнөх оноос 2091 (1.9%)-ээр, 2015 оноос 4043 (3.7%)-аар өссөн үзүүлэлттэй байна.



2017 оны байдлаар нийт хүн амын 53701 (49.4%)-г эмэгтэйчүүд, 55067 (50.6%)-г эрэгтэйчүүд эзэлж байна. Хүн амын насны бүтцээр авч үзвэл нийт хүн амд 0-14 насны хүүхэд 29.1, 15-59 насны хүн 63.9, 60-аас дээш насны хүмүүс 7.0 хувийг эзэлж байна.



Аймгийн хэмжээнд 2017 оны байдлаар 4112 өрх толгойлсон хүн байгаагаас 3 хүртэлх хүүхэдтэй 2786, ихэр хүүхэдтэй 253 өрх, 2 ихэр хүүхэд 502 байна.



Аймгийн хэмжээнд 2017 оны байдлаар 4758 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаагийн 2171 (45.6%)-г эмэгтэйчүүд, 1737 (36.5%)-г эрэгтэйчүүд эзэлж байна.



2017 оны байдлаар өрхийн тоо 29912 болж өмнөх оны мөн үеэс 391 (1.3%)-аар, 2015 оноос 596 (2.0%)-аар өссөн үзүүлэлттэй байна. Нийт өрхийн 10251 (34.3%) нь аймгийн төв, хот тосгонд, 19661 (65.7%) нь сумын төв, хөдөөд амьдарч байна.





ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ - Эрүүл мэнд



Аймгийн хэмжээнд 2017 оны байдлаар 2367 жирэмсэн эх шинээр хяналтанд орсны 1942 (82.0%) нь жирэмсний эхний 3 сарын дотор хяналтад орсон байна.



Аймгийн хэмжээнд 2017 оны байдлаар 1712 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 1720 болж, өмнөх оны мөн үеэс амаржсан эх 114 (6.2%)-өөр, амьд төрсөн хүүхэд 116 (6.3%)-аар буурч, амьд төрсөн хүүхдийн 849 (49.3%)-г эмэгтэй хүүхэд эзэлж байна.



Нас барсан хүний тоо 494 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 76 (13.3%)-оор буурч 192 (38.9%)-г эмэгтэйчүүд эзэлж байна. 0-1 хүртлэх хүүхдийн эндэгдэл 19, 1-5 хүртлэх насны хүүхдийн эндэгдэл 7 тохиолдол тус тус бүртгэгдэж, нас барсан хүний 138 (27.9%) нь хорт хавдрын өвчний шалтгаантай байна.



Халдварт өвчнөөр 794 хүн өвчилж бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 84 (11.8%)-аар өссөн байна. Нийт халдварт өвчний 458 (58.8%)-г бэлгийн замын халдварт өвчин, 197 (25.3%)-г сүрьеэ эзэлж байна.




Аймгийн хэмжээнд 95 эрүүл мэндийн 95 байгууллагад их эмч 235, эм зүйч 27, тусгай мэргэжлийн 607, бусад ажилтан 371 ажиллаж байна.






ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ - Эрүүл мэнд

Төрсөн эх



Нас баралт






ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ- Хөдөлмөр



391



433

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд




Өмнөх оны мөн үе
18.9%



Өмнөх сараас
0.7%

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн иргэд 2017 онд 824 болсон бөгөөд үүнээс 433 (52.5%) нь эмэгтэйчүүд, 391 (47.4%) нь эрэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүйчүүд өмнөх оны мөн үеэс 192 (18.9%)-оор, өмнөх сараас 6 (0.7%)-аар тус тус буурсан байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшингээр



2017 оны 12 сард бүртгэлтэй ажилгүйчүүдээс идэвхгүйн улмаас 43 хүн хасагдаж, 46 хүн ажилд зуучлагдан орж, 83 хүн шинээр бүртгэгдсэн байна. Шинээр 1011 ажлын байр бий болж ХАА ан агнуур ой аж ахуй загас агнуур, боловсруулах үйлдвэр, худалдаа гэр ахуйн засвар үйлчилгээний салбар тус тус 77.2 хувийг эзлэж байна



Улсын Статистикийн Хэлтэс



ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ- Хөдөлмөр

Аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийг бүсчилж үзвэл: Бэлчирийн бүсэд 278 (33.7%) нь, Ерөөгийн бүсэд 62 (7.5%) нь, Хараагийн бүсэд 285 (34.6%) нь, Орхоны бүсэд 139 (16.9%) нь, Сэлэнгийн бүсэд 60 (7.3%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд байна.

Бэлчирийн бүс
33.7%

Ерөөгийн бүс
7.5%

Хараагийн бүс
34.6%



Орхоны бүс
16.9%

Сэлэнгийн бүс
7.3%



ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ- Нийгмийн даатгал, халамж

01

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2017 оны байдлаар 29,982.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2,345.5 (7.8%) сая төгрөгөөр өссөн байна. Харин нийгмийн даатгалын сангийн авлага 7,719.5 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 374.3 (4.8%) сая төгрөгөөр өссөн байна.

02

2017 онд тэтгэврийн даатгалын сангаас 15994 тэтгэвэр авагчдад 55132.6 сая төгрөгийг тэтгэвэрт, Тэтгэмжийн даатгалын сангаас 7365 хүнд 2515.6 сая төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулга, өвчтөн сахисны тэтгэмжид, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин, даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 305 хүнд 1109.7 сая төгрөг, Ажилгүйдлийн даатгалын сангаас 568 хүнд 805.1 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид, эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлэг, эмийн сангуудад 5363.1 сая төгрөгийн зардлыг тус тус олгожээ.

03


Нийгмийн халамжийн сангаас 37149 хүнд 9861.4 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг олгожээ. Үүнээс халамжийн тэтгэврийг 2820 хүнд 3845.6 сая төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 1652 хүнд 980.6 сая төгрөг, жирэмсэн болон нярай хүүхэдтэй 1629 эхэд 712.7 сая төгрөгийг тус тус олгожээ.



ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ- Гэмт хэрэг




2017 оны байдлаар Цагдаагийн газрын мэдээгээр нийт 729 гэмт хэрэг бүртгэгдсэний 230 нь согтуугаар үйлдэгдсэн ба гэмт хэргийн тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 9.0 хувиар өсч гэмт хэргийн илрүүлэлт 67.3 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 12.5 хувиар буурсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 24.4 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 36.2 хувийг хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 6.8 хувийг нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 13.6 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 19.0 хувийг бусад төрлийн гэмт хэрэг эзэлж байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 23.6 хувийг малын хулгай эзэлж байна.





Сэлэнгэ аймгийн Алтанбулаг болон Сүхбаатар боомтоор давхардсан тоогоор 716490 зорчигч нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеээс 53.8 хувиар буурсан байна. Нийт зорчигчдын 83.1 хувь нь Монгол иргэд, 16.9 хувь нь гадаад иргэд байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хилээр нэвтэрсэн Монгол иргэдийн тоо 50.5 хувиар , гадаад иргэдийн тоо 21.1 хувиар буурсан байна. Монгол-Оросын хилийг хялбарчилсан журмаар хил нэвтрэх эрхийн үнэмлэхээр 56470 хүн зорчсон байна.

Хилээр орсон, гарсан иргэд





МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ–Банкны мэдээ

01

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2017 оны байдлаар **232111.5 сая төгрөг** болж, өмнөх сараас 8324.6 (3.6%) сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 25286.3 (10.9%) сая төгрөгөөр өсчээ.

02

2017 оны байдлаар иргэдийн мөнгөн хадгаламж 77.3 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 4.2 (5.4%) тэрбум төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 14.7 (19.0%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

03

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2017 оны байдлаар 6198.5 сая төгрөг болж, өмнөх сараас 386.5 (5.9%) сая төгрөгөөр өсч, өмнөх оны мөн үеэс 757.0 (12.2%) сая төгрөгөөр буурсан байна.





МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ–Банкны мэдээ

Банкууд	Цэвэр		Зээлийн өрийн үлдэгдэл	Чанаргүй зээл	Иргэдийн мөнгөн хадгаламж	Харилцахын үлдэгдэл
	Орлого	Зарлага				
дүн	53,725,452.8	52,492,807.1	232,111,699.6	6,198,932.3	77,315,144.6	29,448,538.8
1.Хаан банк СБ	11,308,316.8	7,452,968.3	82,619,687.4	1,455,050.9	22,032,400.2	9,688,854.3
2.Хаан банк ЗХ	7,246,196.8	8,839,194.7	39,642,882.3	527,960.7	10,792,245.9	8,424,663.6
3.ХХБанк ЗХ	1,520,625.7	1,384,602.7	5,678,137.3	8,632.0	3,036,080.4	3,108,650.5
4.ХХБанк Хөтөл	3,454,378.3	3,618,907.3	5,333,600.2	306,226.4	1,844,875.5	387,899.4
5.Төрийн банк СБ	18,365,754.00	18,219,569.0	45,322,024.7	804,693.0	14,479,975.5	5,021,660.8
6.Төрийн банк ЗХ	6,424,339.8	6,887,348.5	11,142,537.2	50,764.4	4,669,502.6	665,984.8
7.Хас банк СБ	1,409,946.7	1,443,088.7	13,326,235.1	682,017.1	6,160,173.5	688,714.1
8.Хас банк ЗХ	881,924.2	691,584.9	11,542,748.2	267,551.7	5,240,077.6	260,349.8
9.Хас банк Хөтөл	686,337.9	698,804.0	5,133,176.7	347,349.5	2,184,019.3	160,235.0
10.Голомт банк	2,246,832.7	2,884,001.1	11,735,337.3	1,704,497.1	5,731,389.0	928,374.8
11.Капитал банк	180,799.9	372,737.9	635,333.2	44,189.5	1,144,495.1	113,151.6





МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ–Банкны мэдээ






МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ–Төсөв, татвар

2017 оны төсвийн гүйцэтгэлийн 12-р сарын мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 109.3 хувь, улсаас авах санхүүгийн дэмжлэг 100.0 хувь, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 100.0 хувь, салбарын байгууллагуудын тусгай зориулалтын шилжүүлэг 100.0 хувь биелэгдсэн байна. Төсвийн зарлагын гүйцэтгэл 91.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Аймгаас олгох сумдын санхүүгийн дэмжлэг 100.0 хувь, аймгийн Засаг даргаас олгох нөөц хөрөнгийн гүйцэтгэл 95.8 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Татварын орлогын гүйцэтгэл 27371.6 сая төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 119.6 хувьтай байна.

Орон нутгийн төсвийн орлого, зарлага, сая.төг






ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Аж үйлдвэр

2017 оны байдлаар аж үйлдвэрийн салбарт 305.8 тэр.бум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 394.1 тэр.бум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь урьд оны мөн үеийнхээс үйлдвэрлэлт 0.6 хувиар буюу 1.9 тэр.бум төгрөг, борлуулалт 41.0 хувиар буюу 114.7 тэр.бум төгрөгөөр тус тус өссөн байна. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 25.8 хувь нь хүнсий салбарт 54.5 хувь нь уул уурхайн салбарт, 17.0 хувь нь бариилгын материалын салбарт, 2.7 хувийг бусад салбарт бүтээгджээ. Сумдын жижиг дунд үйлдвэрүүд аймгийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 0.4 хувьтай тэнцэх 1189.5 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1370.8 сая.төгрөгийн борлуулалт хийжээ.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт (сая.төг)






ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хөдөө аж ахуй



2017 оны байдлаар ургац хураалтын явцын мэдээгээр үр тариа 152.0 мян.тн, төмс 28.5 мян.тн, хүнсний ногоо 30.8 мян.тн хураан авчээ. Үүнийг 2016 оны мөн үетэй харьцуулахад үр тариа 92.6 мян.тн буюу 37.8 хувиар, төмс 14 мян.тн буюу 32.9 хувиар, хүнсний ногоо 1.9 мян.тн буюу 32.9 хувиар тус бүр бага ургац хураан авсан байна.





ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хөдөө аж ахуй



2017 оны байдлаар 554.5 мянган эх мал төллөсөн нь урьд оны мөн үеэс 45.3 мянган толгойгоор бага байна.



Аймгийн хэмжээгээр 529.9 мянган толгой төл бойжиж байгаа нь урьд оны мөн үетэй харьцуулахад 39.2 мянган толгой буюу 4.6 хувиар бага байна.



2017 оны байдлаар нийт малын 4.3 хувьтай тэнцэх 69.6 мянган толгой мал хорогдсон нь урьд онтой харьцуулахад 20.7 дахин өсчээ.

Хорогдсон нийт малын 11.9 хувийг өвчнөөр хорогдсон, 31.1 хувь нь хээлтэгч малын хорогдол байна. Хорогдсон нийт малын 43.7 мянган толгой буюу 62.8 хувь Ерөө, Зүүнбүрэн, Орхонтуул, Хүдэр, Жавхлант, Хушаат сумдад ногдож байна.



Бусад



Аймгийн Мэргэжлийн хяналтын газар он гарснаар 497 аж ахуйн нэгж байгууллага, 654 иргэнд хяналт, шалгалт хийж, 1312 зөрчил дутагдал илрүүлж, 591 зөрчил арилгуулсан байна.



2017 оны байдлаар Санхүү, Хяналт аудитын алба нийт 82 аж ахуйн нэгж байгууллагад хяналт, шалгалт хийж 184 зөрчил илрүүлж, 250 аж ахуй нэгж байгууллагад зөвлөмж өгч ажиллаа.



Сэлэнгэ аймгийн хэмжээнд он гарснаар 570 объект, 1758 айл өрх үзлэг шалгалтанд хамрагдаж, 1920 зөрчил илрүүлэн, 418 зөрчил дутагдлыг арилгасан байна. Мөн эхний 12 сарын байдлаар 113 гал түймэр гарч 474.1 сая төгрөгийн хохирол учирсан байна.



Сум дундын 20-р шүүхийн мэдээгээр 4-р улирлын байдлаар 908 хэрэг шийдвэрлэснээс 134 нь эрүүгийн хэрэг, 749 нь иргэний хэрэг, 25 нь захиргааны хэрэг байна. 4-р улирлын байдлаар бүгд 140 хүн ял шийтгүүлсэн ба үүний 13 нь эмэгтэй байна.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд нийт 260 гүйцэтгэлийн материал байсан ба энэ оны байдлаар 629 материал нэмэгдэж, 31 материал хасагдсан ба бүгд 858 гүйцэтгэлийн материалаар 3424.7 сая төгрөгийн өрийг барагдуулахаас 459 гүйцэтгэлийн материалаар 1341.8 сая төгрөгийн өрийг барагдуулжээ



Бусад



2017 оны байдлаар төрөөс үнэгүй хувьчилсан газрын эзэмших эрхийн анхны баталгаажуулалтыг 29 иргэн, газраас бусад ҮХЭХ0Э-н анхны бүртгэл, баталгаажуулалтыг 517 иргэн тус тус баталгаажуулжээ. Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ 149, газар өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ 2876 бичигдэж, нийт үйлчилгээний хураамж 181.6 сая төгрөг, ҮХЭХ0Э-ээ худалдсанаас оруулсан татварын орлого 227.5 сая төгрөг төвлөрсөн байна.



2017 оны байдлаар газар өмчлөх тухай өргөдөл 1509 иргэн гаргаснаас 149 иргэн одоо эзэмшиж ашиглаж байгаа хашааныхаа газрыг өмчлөхийг хүссэн иргэдийн 1159 иргэн нь шинээр газар өмчилж авахыг хүссэн иргэд байна. Засаг даргын захирамжаар 1913 иргэнд газар өмчлүүлэхээр шийдвэрлэсэн ба үүний 121 иргэн одоо ашиглаж байгаа газраа, 1531 иргэн шинээр газар өмчилж, 259 иргэн улсын чанартай зам дагуу газар өмчилж авсан байна.



СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?

Статистик
мэдээллийн лавлах
утас 1900-1212

Статистик мэдээллийн
нэгдсэн сан
WWW.1212.mn

Статистик мэдээллийн аппликейшн



Сэлэнгэ Статистик

Selenge.nso.mn

www.nso.mn сайтын
Хэрэглэгчийн бүртгэл
мэдээлэл авах



@statistic_mn

Олон улсын худалдааны төв,
төрийн үйлчилгээний
танхим



Утас: 70362449
70362047